

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2019 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Нэг: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний ажлын албаны талаар:** Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хуралдаан тайлант сард нэг удаа хуралдаж, “Газар тариалан” хөтөлбөр батлах тухай 20, “Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр батлах тухай 21, “Бэлчээр ашиглалтыг сайжруулах” хөтөлбөр батлах тухай, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” батлах тухай, “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулахаар өргөн мэдүүлэх тухай, Нөхөн сонгууль товлон зарлах тухай, Төрийн дээд шагналаар шагнуулахаар өргөн мэдүүлэх тухай зэрэг асуудал хэлэлцэж 7 тогтоол баталлаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар хамтран Манхан сумын иргэд, аж ахуй нэгж байгууллага, төрийн албан хаагч нарт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Жолоочийн албан журмын даатгалын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хууль эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, дээрх ажилд төрийн албан хаагчдын оролцох хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор сургалт, мэдээлэл хийлээ. Мөн төрийн байгууллагуудын дунд хууль эрх зүйн чиглэлээр дэвжээ тэмцээн зохион байгуулав.

Аймгийн ИТХ-д 4 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар иргэдээс 8 өргөдөл хүсэлт хүлээн авч, 6 өргөдөлийг шийдвэрлэн иргэнд мэдээлж, 2 иргэний өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Төлөөлөгчдийн өдөр” арга хэмжээг зохион байгуулав. Тус арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын ИТХ-ын ажлын алба, сумын Төлөөлөгчид, сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хар–Ус нуур орчны Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа, Сум дундын ойн анги, Ус цаг уур, орчны шинжилгээний албаны мэргэжилтнүүд оролцож, байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлууд, тулгамдсан асуудал, цаашид хэрхэн яаж шийдвэрлэх зэргээр байгууллагуудын төлөөлөл танилцуулга хийж, санал бодлоо солилцлоо.

Төлөөлөгчдийн өдрөөр байгаль орчны салбар байгууллагуудын тайлан мэдээлэл сонсож, цаашид салбарын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн яаж шийдвэрлэх талаар харилцан санал солилцов.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, хяналт тавих, олон нийтэд нээлттэй хүргэх зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 27 дугаар тогтоолоор “Сумын ИТХ болон багийн ИНХ-ын үйл ажиллагааг үнэлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх журам”-ын хэрэгжилтийн хүрээнд аймгийн ИТХ-ын

Нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Зэрэг, Дуут, Манхан, Мөнххайрхан сумдад ажиллаж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажиллав.

**Хоёр: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 26 өргөдөл бичгээр хүлээн авч, 16 өргөдлийг шийдвэрлэж, 10 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 9 өргөдөл бичгээр хүлээн авч, 9 өргөдлийг шийдвэрлэж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 3 өргөдөл бичгээр хүлээн авч, 2 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байгаа ба өргөдөл гомдлын шийдвэрлэлт 71.1 хувийн шийдвэрлэлттэй байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 2 сувгаар 30 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 24, биечлэн 6 санал хүсэлт ирүүлснээс гомдол 11, санал хүсэлт 18, шүүмжлэл 1 бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 27 иргэний санал хүсэлтэд хариу өгч шийдвэрлэлт 90.0 хувьтай байна. Үүнд: Халаалтын асуудлаар 2, боловсролын асуудлаар 1, эрүүл мэндийн асуудлаар 4, орчны эрүүл ахуйн асуудлаар 8, хууль эрх зүйн асуудлаар 3, бусад асуудлаар 12 иргэн тус тус ханджээ.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл тайлант сард санал хүсэлтийн хайрцагт бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 1 санал хүсэлт, 2 гомдол хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, 1 гомдол, 1 санал хүсэлтэд хариу илгээж, 1 гомдол шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Нэг цонхны үйлчилгээнд Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 14 төрлийн үйлчилгээгээр 677 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 6616 иргэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 1 байцаагч 2 төрлийн үйлчилгээгээр 57 иргэнд нийт 6 мэргэжилтэн 31 төрлийн үйлчилгээгээр 7350 иргэнд үйлчилгээ тус тус үзүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/203 дугаар захирамжаар байгуулагдсан 2 ажлын хэсэг хөдөөгийн 16 суманд 04 дүгээр сарын 10-18-ны өдрүүдэд "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил", "Хариуцлагатай, тунгалаг төр" хөтөлбөрийн хүрээнд "Нээлттэй хаалганы өдөр"-ийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлэгийн газар, Прокурорын газар, Цагдаагийн газар, Хөгжимт драмын театр, Хэвлэл мэдээллийн байгууллага, Хөгжил политехник коллеж зэрэг байгууллагуудаас 44 төрийн албан хаагч үндсэн чиг үүргийн дагуу иргэдэд мэдээлэл өгч, иргэдийн санал, гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авч, 81 төрлийн үйлчилгээгээр 7940 иргэнд төрийн үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэж ажиллав.

**Гурав Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:** Орон нутгийн төсвийн байгууллагуудын 4 дүгээр сард улсын төсвөөс авах санхүүжилт 16994,5 сая төгрөг

бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардал, ОНХС-ийн зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 3293,1 сая төгрөг, орон нутгийн төсвийн байгууллагуудад 5670,5 сая төгрөг, халамжийн санд 35,0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 8011,0 сая төгрөг, цэцэрлэг 3396,5 сая төгрөг, хүн эмнэлэг 1876,0 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 134,0 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 98,4 сая төгрөг тус тус олгосон.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр, авлагыг нэгтгэн гаргаж, Сангийн яаманд хүргүүлэн нийтэд мэдээлж байна.

Орон нутгийн төсвийн 154 байгууллага, төсөл, сангийн 36, ОНӨААТҮГ-ын 8, бусад 4 нийт 202 байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсныг хүлээн авч хянан “Е” цахим тайлангаар нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2018 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн Аудитын газар аудит хийж “Зөрчилгүй санал” дүгнэлт өглөө.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 5764 ширхэг зардлын ваучер бичиж 28140,4 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн төдийгүй 1659 аж ахуйн нэгж, хувь хүний мэдээллийг засварлаж, шинээр орууллаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Теле маркетинг” үйлчилгээгээр төсвийн захирагч, нягтлан бодогч нийт 300 гаруй алба хаагчдад мессежээр чиглэл өгч ажиллав.

Орон нутгийн төсвийн 2019 оны 1 дүгээр улирлын урьдчилсан гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж цаашид анхаарах асуудлын чиглэлийн талаар танилцуулга бичиж аймгийн удирдлагууд болон сонирхсон иргэдэд нээлттэй мэдээлж ажиллав.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/247 дугаар захирамжаар нягтлан бодох бүртгэлийн “Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэг”-ийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/117 дугаар тушаалын хавсралтаар ирүүлсэн “Түүвэр шалгалт явуулах ажлын удирдамж”-ийн хүрээнд аймгийн нийт аж ахуйн нэгж, байгууллагуудаас түүвэрлэн 91 байгууллага сонгон үзлэг шалгалтанд хамруулж байна.

Мөн Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хөрөнгийн үнэлгээ, аудитын үйл ажиллагаа, татварын итгэмжлэгдсэн эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудад хяналт шалгалт хийж байна.

Нэгдүгээр улирлын байдлаар орон нутгийн төсвийн орлогод 2428,2 сая төгрөг орж, төлөвлөгөө 162,5 сая төгрөгөөр буюу 6,3 хувиар, үүнээс татварын орлогоор 2107,9 сая төгрөг орж төлөвлөгөө 235,6 сая төгрөгөөр буюу 11,1 хувиар, хөрөнгийн орлогоор 0,8 сая төгрөг орж төлөвлөгөө 14,2 сая төгрөгөөр буюу 94,5 хувиар тус тус

тасарч, татварын бус орлогоор 319,4 сая төгрөг оруулж төлөвлөгөө 87,4 сая төгрөгөөр буюу 37,6 хувиар давсан гүйцэтгэлтэй байна.

Дээд шатны төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 2478,9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 9757,3 сая төгрөгийг тус тус бүрэн авч, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 58,3 сая төгрөгөөр дутуу ирсэн.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 15077,2 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 2055,7 сая төгрөгөөр, үүнээс орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зарлага 3707,3 сая төгрөг хүрч, 1076,3 сая төгрөгөөр, орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын зарлага 11369,9 сая төгрөгт хүрч, 979,4 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зарлага 200,7 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 393,2 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжсэн урьдчилсан дүнтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарлага 1917,9 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан нь шилжих хөрөнгө оруулалтаар хийгдсэн байна.

Орон нутгийн төсвийн өр 354,2 сая, авлага 731,7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс өр 83,2 сая, авлага 233,0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нэгдүгээр улирлын байдлаар улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 577,5 сая төгрөг оруулахаас 560,8 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 16,7 сая төгрөгөөр буюу 97 хувиар дутуу биелүүлсэн байна.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагуудын өөрийн орлогод 40,1 сая төгрөг орж, төлөвлөгөө 100 хувийн биелэлттэй байна.

Боловсролын салбарын төсвийн зарлага 9839,3 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 686,2 сая төгрөгөөр дутуу гарч, өр 251,0 сая, авлага 2,1 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 131,0 сая төгрөгөөр нэмэгдэж, авлага 26,5 сая төгрөгөөр буурсан, өрийг оны эхэнтэй харьцуулахад 199,9 сая төгрөгөөр өссөн байна.

Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлага 1325,3 сая төгрөг болж төлөвлөснөөс 264,9 сая төгрөгөөр дутуу гарч, өр 44,2 сая, авлага 8,0 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 10,2 сая төгрөгөөр өсөж, авлага 3,1 сая төгрөгөөр буурсан, өрийг оны эхэнтэй харьцуулахад 35,9 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт өрийг эдийн засгийн ангиллаар задлахад ажиллах хүчинтэй холбогдсон зардал 226.3, тогтмол зардал 66.9, хангамж, бараа материалын зардал 14,7 сая, норматив зардал 40,4 сая төгрөгийн өр ихэнхийг эзэлж байгаад дүн шинжилгээ хийж өрийг барагдуулах арга хэмжээ авч байна.

Аймгийн Татварын хэлтэс НӨАТ-ын 294 тайланг 100 хувь хүлээн авч, 123 татвар төлөгчдөд лавлагаа тодорхойлолт гаргаснаас виз хүссэн 62, зээл авах 31, зөвшөөрөл сунгах 1, тендерт оролцох 23, бусад 6 лавлагаа тодорхойлолт олголоо.

Тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн Улсын бүртгэл, Статистикийн хэлтэстэй тулгалт хийж Тахаст болон Trips програмд бүртгэл хийлээ. Үүнд: Хязгаарлагдмал хувьцаат 24, төсөвт байгууллага 2, төрийн бус байгууллага 7, нийт 34 аж ахуйн нэгж байгууллага бүртгэсэн.

Хөндлөнгийн мэдээллийг цуглуулах, бүхийл эх үүсвэрийг татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж хэвших, хөндлөнгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтийг хангаж ажилласнаар 80 ширхэг 812,4 сая төгрөгийн мэдээллийг цуглуулав.

Хяналт шалгалтанд 18 татвар төлөгчийг хамруулж, гаалийн мэдээлэл болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийснээр шалгалтын явцад 352.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 35,2 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 15,2 сая төгрөгийн торгууль, 7,5 сая төгрөгийн алданги, 57,9 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдууллаа.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 4 дүгээр сарын 9-22-ны хооронд Дөргөн сумын төсөвт байгууллагуудын 2016-2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

Сумын төсөвт байгууллагуудад хийсэн шалгалтаар сумын хэмжээнд нийт 94 хүнтэй холбоотой 39,330.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 15,833.9 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар, 9,498.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд орлого авахуулахаар, 345.0 мянган төгрөгийн цалин хөлс, тэтгэмж буцаан олгохоор шийдвэрлэж, улсын байцаагчийн 25 акт, 6 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

#### **Дөрөв: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:**

**Цагдаагийн газар:** Тайлант сард иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Улсын хэмжээнд зохион явагдаж байгаа хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Ачааны автомашин”, залилах гэмт хэрэг, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Залилан”, “Байгалиа хамгаалъя”, гэмт хэрэгтэй тэмцэх, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй эрүүгийн хэргийг илрүүлэх чиглэлээр “Автомашин-2019” нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд салбар дундын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Байгалиа хамгаалъя", "Залилан" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Баруун бүсийн төв зах дотор "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийн талаар, залилах гэмт хэргийн түгээмэл үйлдэгдэж байгаа үйлдлийн аргыг иргэдэд мэдээлэх, таниулах, залилагч этгээдэд мөнгө, эд зүйлээ өгөхөөс татгалзах, хохирохоос урьдчилан сэргийлж болгоомжлох чиглэлээр иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх яриа таниулга хийж, санал, хүсэлтийг хүлээн авч, 300 гаруй хүнийг хамруулж, 9 төрлийн 300 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, гарын авлага тарааж мэдээлэв.

Жаргалант сумын төрийн 16 байгууллагын 372 ажилтан, алба хаагчдад “Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сургалт зохион байгуулж, санамж, сэрэмжлүүлэг өгч ажиллав. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийн хүрээнд “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагаас бүрдсэн ажлын хэсгийн хамт 16 суманд ажиллаж, мэдээлэл, сурталчилгаанд 4500 гаруй иргэн хамрагдаж, 500 гаруй иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, 18 төрлийн 3000 ширхэг сэрэмжлүүлэг, зөвлөмжийг тараан өгч, 93 иргэний санал, хүсэлтийг хүлээн авсан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Манхан сумын Засаг даргын Тамгын газартай хамтран сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн алба хаагчдад хууль сурталчлах, хууль зүйн зөвлөгөө өгөх нэг өдрийн арга хэмжээг зохион байгуулж, энэ үеэр сумын төрийн алба хаагчдын дунд “Дэвжээ” тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд төрийн байгууллагуудын 7 багийн 42 алба хаагч оролцож, хууль эрх зүйн мэдлэг, авхаалж самбаа, авъяас, чадвараа сорин өрсөлдөж, Соёлын төв, цаг уурын хамтарсан “Эв-Эе” баг тэргүүн байранд, ерөнхий боловсролын сургуулийн “Залуусын түүчээ” баг дэд байранд, спортын ордны “Таван цагариг” баг гутгаар байранд тус тус шалгарч шагнаж урамшууллаа.

Орон нутгийн 2 телевизтэй хамтран ажиллаж, аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион явуулсан сургалт, уралдаан тэмцээн, уулзалт, зөвлөгөөн, бусад ажил, арга хэмжээний талаар иргэд, олон нийтэд тухай бүр мэдээлэл, сурвалжлага хүргэв.

“Теле камерын хяналтын нэгдсэн төв” нь эрэн сурвалжилж байсан нэг хүний маршрутыг тогтоон, камерын хяналтаар 22 зөрчил илрүүлж, таксинд гар утас, эд зүйлээ мартсан гэх 15 иргэний хүсэлтийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 2019 оны 4 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 52 гэмт хэрэг бүртгэгдсэн, бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 4, Хулгайлах гэмт хэрэг 12, Мал хулгайлах гэмт хэрэг 10, Залилах гэмт хэрэг 4, Заналхийлэх 1, алдаатай гүйлгээ андуурсан илгээмж завших 1, завших 2, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 4, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах 1, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 3 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн.

Цагдаагийн газарт тайлант сард иргэд хуулийн этгээдээс 261 гомдол мэдээлэл хүлээн авсан, үүний 79 буюу 30,2 хувийг гэмт хэргийн шинжтэй, 182 буюу 69,8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байв. Хүлээн авсан гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 17, бусдын биед халдах 4, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 7, авлига 1, залилах 8, зам тээврийн осол /хүн нас барсан, эд материалын хохирол учирсан/ 9, мал хулгайлах 9, ОНАТБА 19, завших 3, худалдаа үйлчилгээний журам зөрчсөн 11, хулгайлах 17, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2, хүний бэлгийн

эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 1, хууль сахиулагчийг эсэргүүцэх 4, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 4, эдийн засгийн эсрэг гэмт хэрэг 2, бусад 130 гомдол мэдээлэл тус тус хүлээн авсан.

Цагдаагийн газраас 4 дүгээр сарын 25-ны байдлаар зөрчил гаргасан 129 хүнийг саатуулж, зөрчил гаргасан 172 хүнийг 22,265,000 мянган төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 97 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 53 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулсан болохыг танилцуулъя.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар – 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги:** Тус анги нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон ангийн хэвийн үйл ажиллагаа, хоригдол, хоригдогч нарын аюулгүй байдлыг хангах, тэдний дундаас гарч болзошгүй аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх ажлын чиглэлээр үйл ажиллагааг явуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2018-2019 онд албаны сургалт зохион байгуулах хөтөлбөр”-ийн хүрээнд хичээл сургалтуудыг үр дүнтэй, чанартай хүртээмжтэй зохион байгуулахад анхаарч, сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 7 хоног бүрийн мягмар гарагийг хичээл сургалт, спортоор хичээллэх өдөр болгож, тасаг нэгжийн дарга нараар болон төрийн, төрийн бус байгууллагаас холбогдох чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан, мэргэжлийн сургагч багш нартай хамтран хичээл сургалтыг зохион байгуулж алба хаагчдын идэвх оролцоог дээшлүүлэн ажиллалаа.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор “Миний гэр бүл-Миний аз жаргал” аян өрнүүлж, алба хаагчдын дунд сургалт, нөлөөллийн ажлуудыг хийж гүйцэтгүүллээ. Аяны хүрээнд “Замын хөдөлгөөний соёлыг өөрөөсөө эхэлье”, “Эх түүхээрээ бахархъя” уриан дор тус ангийн “Эцэг эхийн зөвлөл”-өөс санаачлан “Өв соёлын хүрээлэн”, “Орон нутгийг судлах музей”-тэй хамтран алба хаагчдын ар гэр, хүүхдүүдийг оролцуулан танин мэдэхүйн танилцах аялал зохион байгууллаа.

Алба хаагчид болон тэдний ар гэр, хүүхдүүдэд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм” 2 цагийн сургалт, “Дэлхийн зөн” олон улсын байгууллага, “Гэр бүлийн радио FM-104.0” радиотой хамтран алба хаагчдын дундаас 20 алба хаагчийг сонгон авч эхнэр /нөхөр/-ийн “Гэр бүлийн чухал мөчүүд” ярилцлага хийлээ.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн сургалт сурталчилгаа, мэдээлэл технологи хариуцсан улсын байцаагч, тэтгэврийн улсын байцаагч, сайн дурын даатгалын байцаагч нар алба хаагчдад Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулж нийт алба хаагчдын гар утсанд нийгмийн даатгалын ерөнхий газраас бэлтгэсэн нийгмийн даатгалын мэдээллийн санг суулгаснаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, бусад холбогдох хууль эрх зүйн мэдээллийг гар утаснаасаа бүрэн хянах мэдээлэл авах боломж бүрдлээ.

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/91 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль зүй дотоод хэргийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд зарласан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян 2019” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулж батлуулан “Дэлхийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр”-өө Ховд аймаг дахь “Хөдөлмөр халамж үйлчилгээний газар”, “Сүүн сэтгэл” төрийн бус байгууллага, аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран хичээл, сургалтуудыг зохион байгуулж орон нутгийн “Ховд телевиз”-ээр сурталчлан ажилласан.

**Шүүхийн шинжилгээний алба:** Монгол Улсын хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын тушаал, албан даалгавар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2019 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Иргэдийн хурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэхээр чиглэл баримтлан ажиллав. Алба хаагч нарт 7 хоногийн 5 дахь өдөр тайлант сард 2 удаа өглөөний мэдээлэл хийв.

Шүүхийн шинжилгээний албанд хандаж 43 албан бичиг, шинжилгээ хийлгүүлэх 90 тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч, тухай бүр шийдвэрлэж ажиллав.

Эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлж хариуг албаны цахим [khovd\\_nifs@yahoo.gov](mailto:khovd_nifs@yahoo.gov) хаягаар хүлээн авч ажиллаж байна.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 7 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 84, эд эсийн шинжилгээ 7, хавтаст хэрэг 1, химийн шинжилгээ 21, биологийн шинжилгээ 8, криминалистикийн 7 шинжилгээнд дүгнэлт гаргаж ажиллав.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 43 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 52 ширхэг мөр, гутлын мөр 14, тээврийн хэрэгслийн мөр 16, бичил мөр 1, бусад ул мөр, эд мөрийн 3 баримтыг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 34, гарын 14 мөр авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийлээ.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бүтцийн, химийн, биологийн, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүд болон ирүүлсэн тогтоолуудыг тухай бүр цахим санд шивж баталгаажууллаа.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тус хэлтэс тайлант сард нийт 3250 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас шилжих хөдөлгөөнд хамрагдсан 230 иргэд, шилжин ирсэн 65 иргэд, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 165 иргэн, 764 иргэнд гадаад паспорт олгож, иргэний бүртгэлийн чиглэлээр нийт 1984 иргэнд үйлчилгээ үзүүлэв.

Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлээр нийт 322 иргэнд үйлчилгээ үзүүлсэн Үүнээс: төрөлт 203, үрчлэлт 6, овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 18, эцэг тогтоолт 15, гэрлэлт 34, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 13, нас барсны



бүртгэл 43, нөхөн бүртгэл 8, регистр олголт 3, иргэний бүртгэлийн лавлагаа олголтоор 218 иргэнд тус тус үйлчлэв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 984, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 282 иргэнд холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав.

Иргэдээс нийт 11 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд 5 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлсэн, 4 өргөдлийн хугацаа болоогүй шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

**Тав: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:**

**Боловсролын чиглэлээр:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбор хамтран сурагчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Хандлагаа өөрчилъе” уриан дор зохион байгуулсан “Ногоон паспорт эзэмшигч багш, сурагчдын уулзалт” арга хэмжээ зохион байгууллаа.

Сургууль, цэцэрлэгийн эмч нарт шинэ мэдээ мэдээлэл өгөхийн чацуу харилцан туршлага солилцуулан бие биеэсээ суралцах, сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Давсны зохистой хэрэглээ, Амны хөндийн эрүүл мэнд, Үдийн цайны хяналт, Эрүүл мэндийн статистик мэдээ, Өсвөр үеийн эрүүл мэнд, сургуулийн орчинд хүүхдийн эрүүл мэндийг дэмжих агуулгын хүрээнд сургалт зохион байгууллаа.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар тусгай удирдамжийн дагуу Цэцэг, Булган, Алтай, Үенч, Ховд, Дөргөн сумдын соёлын төв, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, боловсрол, соёлын салбарын хууль тогтоомжийн биелэлтийн явцтай танилцах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Ажиллах явцад давхардсан тоогоор 189 багш, 800 сурагчдаас мэдлэгийн шалгалт авч, 186 цагийн хичээл, үйл ажиллагаанд сууж 412 багшид сургалт хэлэлцүүлэг хийн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч боловсрол, соёл, урлагийн салбараас баримтлах хөгжлийн бодлого, хууль журам, үйл ажиллагааны хөтөлбөр зорилтуудыг орон нутгийн 216 иргэд, 236 багш ажилчдад сурталчлан таниулах, оролцогчдын санал хүсэлтийг сонсох уулзалтыг 7 удаа зохион байгууллаа.

“Музейтэй Монгол” жилийн аяны хүрээнд Музейн үйл ажиллагааг сурталчлах, музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйлсийг олон нийтэд таниулах, хөдөөгийн хүүхэд багачуудад үйл ажиллагаагаа хүргэж ажиллах зорилгоор Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Дөргөн, Мянгад, Зэрэг, Манхан сумдад нүүдлийн үзэсгэлэн гаргаж ажилласан бөгөөд 1000 гаруй хүүхдүүдийг хамруулав.

Аймгийн биет өв, түүхэн хөшөө дурсгалт газруудыг залуу хойч үе, хүүхэд залуучууд, өсвөр үе сурагчдад сурталчлан таниулах, мэдлэг олгох, хайрлан хамгаалах эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор Жаргалант сумын ерөнхий боловсролын 7 сургуулийн 700 гаруй сурагчдад Ховд хотын туг далбаа, логоны бэлгэдлийн талаарх мэдээлэл өгч, аймгийн төвийн түүхэн хөшөө дурсгалууд, Ховд нутгаас төрөн гарсан түүхэн хүмүүсийн

баатарлаг гавъяаг алдаршуулах, шинээр хийгдэж буй бүтээн байгуулалтыг танилцуулах аялалын арга хэмжээ зохион байгууллаа.

Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын Олимпиад зохион байгуулах комисс зөвлөмжийн дагуу Прогресс, Цаст-Алтай сургуулийн багш, 9а ангийн сурагч Номуунзул нарыг байлцуулан сэдвийн битүүмжлэлийг хянуулан задалж сургуулиудад хүргүүллээ. Мөн сургуулийн удирдлага, монгол хэл, уран зохиолын багш нарт олимпиадыг хэрхэн зохион байгуулах тухай зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, хамтран ажиллалаа. Нийт 24 сургуулийн 9 дүгээр ангиудаас шалгарсан нэг бүлэг оролцсон бөгөөд материалыг битүүмжлэн ирүүлж нэгдсэн журмаар комисс тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу засаж дүгнэлээ.

Олимпиадыг МХУЗ-ын багш нар групп онлайнгаар live хийж, авсан ба II даваанд 24 бүлгийн 586 сурагч хамрагдсанаас Прогресс сургуулийн 9а анги 27,17 дундаж оноогоор дараагийн шатанд оролцохоор шалгарч, материалыг дүгнэсэн хүснэгтийн хамт битүүмжлэн улсын олимпиадын хороонд хүргүүллээ.

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан Боловсрол, соёл, урлагийн газар, Нийтийн номын сан хамтран бүх нийтийн монгол бичгийн боловсролыг дээшлүүлэх, үндэсний хэл бичгээ сурах хүсэл зоригийг бадраах, дэмжих зорилгоор "Монгол бичгийн тэргүүний уншигч-2019" уралдаан, мөн "Уран үзэгтэн" хичээнгүй бичгийн уралдаан тус тус зохион байгуулж уралдаанд ерөнхий боловсролын дунд сургуулийн 120 гаруй сурагчид оролцож, шилдэг 10 сурагчийг шалгаруулав.

Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 3 дахь жилдээ зохион байгуулагдах УИХ-ын гишүүн С.Бямбацогтын нэрэмжит "Оюуны их сорилго" олон төрөлт олимпиадын бэлтгэл ажил хийгдэж оролцогчдын мэдүүлгийг авч нэгтгэн мандат олгоход бэлэн болоод байна.

**Соёл, Спортын чиглэлээр:** БСШУС-ын сайдын А/648 тоот тушаал, аймгийн Засаг даргын А/756 тоот захирамжийн дагуу 2018-2019 оны Түүх, Соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг 2018 оны 12 дугаар сарын 06-аас 2019 оны 03 дугаар сарын 31-ний хооронд хийсэн. Тооллогын ажлаар нийт 15 /музей, сумдын Соёлын төвийн орон нутаг судлах танхим, Гандантэгчилэн хийд г.м/ соёлын байгууллагын 1856 дэсийн 4930 ширхэг үзмэрийг тоолж бүртгэлжүүлэв. "Музейтэй Монгол" жилийн аяны хүрээнд Музейн үйл ажиллагааг сурталчлах, музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйлсийг олон нийтэд таниулах, хөдөөгийн хүүхэд багачуудад үйл ажиллагаагаа хүргэж ажиллах зорилгоор Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран 2019 оны 04 дүгээр сарын 18-24-ны хооронд Дөргөн, Мянгад, Зэрэг, Манхан сумдад нүүдлийн үзэсгэлэн гаргаж ажилласан бөгөөд 1000 гаруй хүүхдүүдийг хамруулав.

2019 оны 4 дүгээр сарын 25-ны байдлаар олон угсаатны өв соёлтой танилцахаар нийт 194 үзэгч Музейг үзэж сонирхов.

Төрийн шагналт Ардын жүжигчин Ж.Чулууны нэрэмжит Алтангадас одонт Хөгжимт драмын театр 2019 оны уран бүтээлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу

“Жангар” туульсын дуулалт жүжгийг дахин тоглов. Д.Содномдоржын зохиол “Норовын намтар” хүүхдийн уран бүтээлийг тоглохоор төлөвлөн бэлтгэл ажилдаа ороод байна.

Тайлант сард нийт 15 үйл ажиллагаагаар 6550 гаруй үзэгчид, оролцогчдод үйлчиллээ.

Аймгийн нийтийн номын санд тайлант сард нийт 440 уншигч шинээр бүртгэгдэж, 4850 хүнд 6570 номоор үйлчилгээ үзүүлэв. Соёл нийтийн томоохон ажил болох “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг 4 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн ба 8 удаагийн номын үзэсгэлэн өдөрлөг, уралдаан тэмцээн 6, сургалт мэдээлэл 2, англи хэлний ярианы хичээл 3, кино үзвэр 2, 1 удаагийн нээлттэй хаалганы өдөр тус тус зохион байгуулж нийт 850 гаруй уншигч үйлчлүүлэгчид хамрагдав.

Волейболын идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 4 дүгээр сарын 2-9-ний өдрүүдэд Ховд хотод зохион байгуулагдаж, тус тэмцээнд 21 аймаг, Улаанбаатар хотын дүүргүүдийн нийт 32 багийн 400 тамирчин оролцов. Мөн бүсийн аварга шалгаруулах таеквондогийн тэмцээнд 180 тамирчин, 4 дүгээр сарын 18-24-ний өдрүүдэд аймгийн ЕБС-уудын хүүхдийн “Бага наадам-2019” тэмцээн 9 төрлөөр амжилттай зохион байгуулагдаж 1500 гаруй хүүхэд оролцов.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Иргэдэд эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тайлант сард “Осол, гэмтлээс сэргийлэх тогтвортой хөгжил-2030” салбар дундын үндэсний чуулганыг угтаж “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” сэдэвт өдөрлөгийг аймгийн болон сумдын эрүүл мэндийн 22 байгууллагын 480 орчим эмч, эмнэлгийн ажилчид оролцож ойролцоох авто замын дагуу жагсаж, иргэд, хүүхэд багачуудад зориулан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх уриалга, зөвлөмж, анхааруулга 300 орчим сурталчилгааны материалыг түгээх арга хэмжээг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд - Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж эхлүүлэхээр Ард Аюушийн талбайд 200 гаруй иргэд, хүүхдүүдийг оролцуулан хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж хөтөлбөрийн ач холбогдол, үр дүн, үйлчилгээний чиглэл, эмчлүүлэх хуваарийг иргэд олон нийтэд танилцуулан цахим сайт, орон нутгийн телевизүүдээр мэдээллээ.

Хөтөлбөрт аймгаас 21808 хүүхэд хамрагдаж, тус бүр ЭМД-аас олгох 60 мянган төгрөгөөр амны хөндийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчлэн эрүүлжүүлэх тусламж, үйлчилгээ авах юм. Эдгээр хүүхдүүд сонгон шалгаруулалтад тэнцэж, эрүүл мэндийн даатгалтай гэрээ байгуулсан Содон сондор, Сувдан шигтгээ, Хаш сондор хувийн шүдний эмнэлгүүдэд хуваарийн дагуу эмчлүүлэх бөгөөд эхний ээлжинд буюу 2019 онд 2-6 хүртэлх насны хүүхдүүдийг түлхүү хамруулахаар зорилт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Авилга хүнд сурталгүй аймаг” болох зорилт дэвшүүлэн энэ хүрээнд “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөр хэрэгжүүлэн

хэрэгжилтийн хүрээнд “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” нээлттэй хаалганы өдөр арга хэмжээ зохион байгуулж сум бүрт хүрч ажиллах эрүүл мэндийн ажилтныг томилон 16 суманд ажиллуулж эрүүл мэндийн салбарын ажлыг танилцуулахаас гадна иргэдэд “Сүрьеэ өвчний үед илрэх шинж тэмдэг”, “Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх” 1200 ширхэг гарын авлага материалыг тарааж, “Эх, хүүхдийн эрүүл мэнд”, “БЗДХ өвчин”, “Сүрьеэ өвчнөөс сэргийлэх” сэдэвт богино хугацааны мэдээллийг танилцуулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүллээ.

Эхний улирлын байдлаар сүрьеэ өвчнийг илрүүлэх тандалт судалгааны асуумжийг 583 хүнээс авч рентген шинжилгээнд бүрэн хамруулж, 14 хоногоос дээш ханиалгах шинж илэрсэн 46, хэвийн бус цэр илэрч буй 35 хүнийг шинжилгээнд хамруулан нян судлалаар 2 хүний өвчлөлийг илрүүлж, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн алба хаагч, ажилчдад сүрьеэ өвчний мэдээлэл өгч сургалт зохион байгууллаа. “Давсыг хоолны цэснээс хасъя” сэдэвт сургалтыг цэцэрлэг, сургуулийн эмч, нийтийн зах, хоолны газрын 80 тогоочийг хамруулан мэдээллээр хангах сургалт, сургуулийн үйлчилгээний 24 ажилтанд “Ерөнхий боловсролын сургуулийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодисыг ашиглах заавар, халдвар хамгааллын дэглэм”, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх” талаар сургалт тус тус зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, хүүхдийн эрүүл мэнд, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл хийж танилцууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүн амын эрүүл мэнд, амь насанд аюул учруулж буй элэгний С вирусын халдварын голомтыг 2020 он гэхэд устгаж, элэгний хорт хавдрыг эрт илрүүлж, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтыг эрс бууруулах зорилготой “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа билээ.

Хөтөлбөрийн явц, хэрэгжилтийн талаар ажлын хэсгийн хурал зохион байгуулж түүний үр дүнг хэлэлцлээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр аймгийн хэмжээнд “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн эхний шат буюу 2017 онд эрсдэлт бүлгийн хүн ам болох 40-65 насны 18320 иргэдээс 11175 хүнийг үзлэг шинжилгээнд хамруулж хамрагдалт 61 хувьтай, 2 дахь буюу 2018 онд 16-39 насны 16094 хүнийг хамруулсан нь хамрагдвал зохих хүн амын 46.4 хувийг хамруулж, В,С вирустэй иргэнийг хяналтанд авч эмлэн эрүүлжүүлэх арга хэмжээг авч, лабораторын шинжилгээг сонгон шалгаруулалтанд тэнцсэн “MONA VITA” лабораторын байгууллага нь Эрүүл мэндийн яамтай гэрээгээр гүйцэтгэж, В, С вирусийн шинжилгээ, С вирусийн идэвхжлийг тогтоох шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэн ажиллаж байна.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр иргэдийн эрүүл мэндийн даатгалын хамрагдалт хангалтгүй, иргэд үзлэгт хамрагдсан хэдий ч шинжилгээний үр дүнгээ эргэж тооцдоггүй, нэг лаборатори ажиллаж байгаа тул

ачаалал их, иргэдийн эрүүл мэнддээ тавих анхаарал дутмаг, хөтөлбөрийн талаарх мэдээлэл хомс байгаатай холбоотой хамралт бага байгааг хурлаас холбогдох байгууллагын удирдлагуудад анхааруулж цаашид хийх ажлыг байгууллага бүрээр гаргаж үүрэг чиглэл өглөө.

Азийн хөгжлийн банкнаас “Вируст гепатитын оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулах техник туслалцааны төсөл”-ийг “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж байгаа бөгөөд аймагт тус сургалтыг 4 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, 17 сум, өрхүүдийн эмч, мэргэжилтнүүдийн төлөөлөл 90 орчим хүнийг хамруулан зохион байгууллаа. Энэхүү сургалт нь онолын шинэ мэдээллийг лекцээр сонсож, халдвар хяналт, лабораторийн чиглэлээр дадлага хийх, тохиолдолд суурилсан асуудлыг дадлагаар шийдвэрлэх зэргээр эмч мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг сайжруулсан үр дүнтэй сургалт боллоо.

Энэ оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улс даяар Пневмококкийн эсрэг 13 цент вакцин”, “Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин” хоёр төрлийн вакциныг шинээр нэвтрүүлэхтэй холбогдуулан эрүүл мэндийн салбар байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг чадваржуулах, вакцинтай холбоотой мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор “Пневмококк болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг нийт сум, өрхийн эмч, мэргэжилтнүүдийн төлөөлөл болох 80 гаруй хүн оролцуулан мэдээлэл, арга зүйгээр хангалаа.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс хэрэгжүүлж буй “Тарилгатай халдварт өвчний дархлал тогтоц, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа”-г Алтай, Булган, Буянт, Дөргөн, Жаргалант, Зэрэг, Мөнххайрхан, Мянгад, Үенч, Ховд, Чандмань сумдаас 170 өрхийг судалгаанд хамруулж 112 өрхийн судалгааг дэлгэрэнгүйгээр авч, цусны шинжилгээнд нийт 352 хүнийг хамруулж, цусны ийлдэсийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлээд байна.

Алслагдсан сум багийн малчид, зорилтот бүлгийн ард иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор мобайл технологийг өргөжүүлэх төслийг Буянт, Чандмань сумдад хэрэгжүүлж байсан бол энэ оны 4 дүгээр сараас Үенч сумын эрүүл мэндийн төвийг хамруулснаар сумдынхаа хүн амын 60-70 хувьд нь, зорилтот болон эрсдэлт бүлгийн бүх хүмүүстээ хүрч эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн оношилж шаардлагатай үйлчлүүлэгчдийг 2 дугаар шатны эмнэлэгт шилжүүлэх шийдвэрийг газар дээр нь гаргах боломж бүрдэж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай хамтран эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах “Эмнэлгийн эмч, мэргэжилтний ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 400 гаруй хүнийг хамруулав. Энэхүү эмнэлгийн эмч,

мэргэжилтний ёс зүйн сургалт нь хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж, эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх замаар салбарын үйл ажиллагаа, тогтолцоонд ёс зүйн шинэчлэл хийх боломж бүрдүүлснээрээ онцлог байв.

Тайлант сард эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдал, байгууллагын ажилчдын сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор Цэцэг, Манхан сумын эрүүл мэндийн төв, Мөст сумын сум дундын эмнэлэг, Хөшөөтийн уурхайн эмнэлэг, Жаргалант сумын “Жаргалант удам” уламжлалтын эмнэлэг, “Содон сондор”, “Ара дент”, “Хаш сондор” шүдний эмнэлэгүүдэд халдварын сэргийлэлт хяналт, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын чиглэлээр болон бусад чиглэлээр дэмжлэгт хяналт шинжилгээ үнэлгээ хийлээ.

Эрүүл мэндийн чанарын холбооноос эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал” сэдэвт 5 өдрийн 35 цагийн төлбөртэй сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж, уг сургалтанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Чанарын албаны дарга, холбогдох хүмүүс, Мөнххайрхан, Манхан, Дарви, Дуут, Буянт, Чандмань, Мөст, Эрдэнэбүрэн сумын эмнэлгүүдийн дарга, мэргэжилтнүүд хамрагдсанаар орон нутагт тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах боломж, нөхцлийг сайжруулсан арга хэмжээ боллоо.

**Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн дагуу Ховд их сургуулийн Баруун бүсийн тогтвортой хөгжлийн хүрээлэнгээр гүйцэтгүүлсэн “Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээ 2017” судалгааны тайлангийн мөрөөр төрийн байгуулалт, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, нийтийн тээвэр, үйлчилгээ, байгаль орчин, татварын чиглэлээр иргэдээс гарсан санал гомдлын мөрөөр гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гаргаж ажилласан бөгөөд төлөвлөгөөний биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 87.0 хувьтай хэрэгжсэн дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

“Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийсэн дүнгийн талаар:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны IY хуралдаанаар “Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл”-ийг батлуулж, аймгийн Засаг даргын Тамгын газар болон сум, байгууллагуудын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, сум, байгууллагуудын хяналтад авч хэрэгжүүлж буй үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцтай газар дээр нь очиж танилцан, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

*График 1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 2018 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар*

Д/д	Зорилт	МЖ Ф Н	Үнэлгээ	Нийт	᠑ ᠑
-----	--------	--------------	---------	------	--------

			Хугацаа болоогүй төлөлх боломж- гүй	0	40	70	100	ОНОО		
1	Төрийн уирдлага, эрх зүйн бодлогын хүрээнд	15	1			8	7	1260	84.0	
2	Гадаад харилцааны талаар	6		1		1	4	470	94.0	
3	Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх талаар	11			1	1	8	910	82.7	
4	Эрх зүйн бодлогын талаар	11	1			4	6	880	88.0	
5	Соёл урлагийн талаар	14			1	3	5	970	69.3	
6	Биеийн тамир спортын талаар	7			1	1	3	450	64.3	
7	Эрүүл мэндийн талаар	13				5	8	1150	88.5	
8	Боловсролын талаар	14				1	4	1220	87.1	
9	Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар	17				2	11	4	1250	73.5
10	Эдийн засаг, төсвийн бодлого, зохицуулалтын талаар	13					9	4	1030	79.2
11	Хөдөө аж ахуйн талаар	29		1	2	3	13	10	2030	70.0
12	Худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн талаар	13			1	1	8	3	900	69.2
13	Дэд бүтцийн талаар	34			1	11	11	11	2310	68.0
14	Байгаль орчны талаар	14				1	3	10	1250	89.3
Дүн		211	2	2	7	24	86	91	16080	80.0

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний 11.4 хувь буюу 24 арга хэмжээ 40 хувь, 40.8 хувь нь буюу 86 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй, 43.1 хувь буюу 91 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Үндсэн чиглэлийн биелэлтийг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар тооцож аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхэд 80.0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн нь жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ нь аймаг орон нутгаас шалтгаалаагүй санхүүжилт, ажил хариуцсан албан хаагчдын идэвх санаачлагагүй ажилласан болон зарим арга хэмжээ орон нутагт хэрэгжих боломжгүйтэй холбоотойгоор хэрэгжилтийн явц удааширсан байна.

Үүнд: Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах аймгийн дэд хөтөлбөр боловсруулах, баруун бүсийн спортын бага наадам, “Олимп- 50” арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээнүүд хэрэгжих боломжтой юм.

Олон үндэстэн ястны “Икэл” цогцолборын барилгын ажлыг эхлүүлэх, гялгар уут, хуванцар сав, хаягдал шил дахин ашиглах, боловсруулах жижиг дунд үйлдвэрийг байгуулах ажлуудыг үндсэн чиглэлд тусгасан боловч төсөв санхүүгийн асуудал шийдэгдээгүй, малчдын “Нүүдэлчин” төвийн барилгын ажлыг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор эхлүүлэх ажлын санхүүжилтийг 2019 оны улсын төсөвт тусгасан, мах сүү, хүнсний ногооны шинжилгээний лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж

нийлүүлэх ажлыг сайдтай байгуулсан гэрээнд тусгасан боловч шийдэгдээгүй зэрэг шалтгааны улмаас дээрх 4 арга хэмжээ тасарсан байна.

Мөн аймгийн цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд орчин үеийн ухаалаг тоолуур шат дараатай суурилуулах ажлын санхүүжилт 2018 онд шийдэгдээгүй тул 2019 оны үндсэн чиглэлд тусгуулсан байна.

“Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл”-ийн биелэлт болон хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний дүнг 2019 оны 2/678 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Түүнчлэн 2019 оны 04 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Дэлхийн банктэй хамтран зохион байгуулсан “Харилцан суралцах арга зүй” сэдэвт сургалтанд хэлтсийн ахлах мэргэжилтэн оролцлоо.

Сургалтанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Э.Бат-Идэр болон референт С.Нямбаяр, Б.Мөнх-Эрдэнэ, н.Цэцэг-Өлзий, Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуулийн захирал, дэд проф. Я.Бямбасүрэн, багш, дэд проф. доктор, Ч.Эрдэнэчимэг, БХАН-ийн менежер А.Бүрэнжаргал, Н.Нарантуяа нарын бүрэлдэхүүнтэй сургагч багш нар оролцож, “Харилцан суралцах арга зүй, Нийгмийн эгэх хариуцлага”, “Сайн туршлагыг бүтээсэн арга зам, сургамж, үр дүн”, “Бодлогын баримт бичигт хийсэн хөндлөнгийн үнэлгээ, үр дүн, туршлага”, “Хэрэглэгчийн үнэлгээ, сэтгэл ханамж”, “Харилцан суралцах алхам ба хамтын ажиллагааг хөгжүүлэх”, “Харилцан суралцах арга зүйг түгээн дэлгэрүүлэх, төлөвлөгөө боловсруулах”, “Хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө хуваалцах” зэрэг сэдвээр хичээл зааж, мэдээ мэдээлэл хийв.

Уг сургалт нь ижил түвшний байгууллага, мэргэжилтнүүд өөрийн сайн туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэх, үр дүнд суурилан харилцан суралцаж, хамтран ажиллагчдын дунд талархалтай, харилцан хүндэтгэсэн харилцаа, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт боллоо.

2019 оны 04 дүгээр сарын байдлаар Засгийн газрын тогтоол 30, хуралдааны тэмдэглэл 4, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал 1, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 44 тогтоол хүлээн авч хяналтын карт хөтөлж, аймгийн удирдлагуудад танилцуулж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны “Газар тариалан хөтөлбөр” батлах тухай 20, “Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр” батлах тухай 21, “Бэлчээр ашиглалтыг сайжруулах хөтөлбөр” батлах тухай 22, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах туай 23 дугаар тогтоолуудыг олшруулан (800 хуудас материал) 17 сум болон холбогдох хэлтэс, албан байгууллагуудад албан бичгээр хүргүүлж ажиллав.

**Долоо: Сумдын мэдээлэл:**

**Зэрэг сум:** Иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээгээр иргэдэд үйлчилж, холбогдох хууль журмын дагуу бичиг баримтын бүрдүүлэлт хийж ажилласны зэрэгцээ тайлант сард нийт төрөлт 11, гэрлэлт 2, эцэг тогтоолт 1 бүртгэгдэж 9 иргэнд цахим



үнэмлэх олгох ажлыг хийж гүйцэтгэлээ. Сумын удирдлагууд ажлын хэсгийн хамтаар мал аж ахуйн багуудын ИНХ-д оролцож, багийн иргэдэд цаг үеийн мэдээ мэдээлэл өгч зарим төрийн үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэж ажиллалаа.

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, “Хариуцлагатай, тунгалаг төр” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас холбогдох байгууллагуудтай хамтран иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн зарим үйлчилгээг газар дээр нь шуурхай үзүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг 04 дүгээр сарын 16-ны өдөр сумын ИТХ, ЗДТГ-тай хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди нийт төрийн албан хаагчид болон ард иргэдэд цаг үеийн ажлын талаар мэдээлэл хийж ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд төрийн албан хаагч нарт Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл өгсөн төдийгүй холбогдох байгууллагууд үндсэн чиг үүргийнхээ хүрээнд иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлж ажиллав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн нэрэмжит тойргийн 5 сумын спортын 4 төрөлт тэмцээнийг гар бөмбөг, сагсан бөмбөг, шатар, үндэсний бөхийн төрлүүдээр зохион байгуулж, тэмцээнд 120 гаруй тамирчид өрсөлдөж багийн дүнгээр нэгдүгээр байрыг Зэрэг сумын баг тамирчид, хоёрдугаар байрыг Цэцэг сумын баг тамирчид, гуравдугаар байрыг Дарви сумын баг тамирчид тус тус эзэллээ.

Сум хөгжүүлэх сангаас 2010-2016 онуудад зээл авсан зээлийн үлдэгдэлтэй 12 иргэнд сануулга бүхий хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлж заасан хугацаанд зээлийн эргэн төлөлтөө бүрэн төлж дуусаагүй иргэнийг шүүхийн шатанд хүргүүлэх арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Сумын Эрүүл мэндийн төвөөр тайлант сард нийт 361 хүн үзлэгт хамрагдсанаас урьдчилан сэргийлэх үзлэгт 98, диспансерийн хяналтад 62, гэрийн идэвхтэй эргэлтэд 3, амбулаторийн үзлэгт 195 иргэн хамрагдаж гэрийн дуудлагаар 3 иргэнд үйлчилж, 16 хүнийг 13А маягтаар дээд шатлалын эмнэлэгт шилжүүллээ. ЭХО оношилогоогоор 58 хүн үзүүлж онош тодруулсан, нийт 71 өвчтөнийг хэвтүүлэн эмчилж, 437 ор хоног ашигласан. Жирэмсний хяналтад 46 жирэмсэн эх байгаагаас шинээр эхний 3 сартайд 5 эхийг хяналтад аваад байна.

“Ээлтэй эмч” долоо хоногийн аяны хүрээнд ард иргэдэд артерийн гипертензийн үзлэг 69 хүнд хийж 159 хүнд гарын авлага боршур тараасан. “Сүрьеэ өвчинтэй тэмцэх өдрийг тохиолдуулан БОЭТ-ийн сүрьеэгийн эмч нар үзлэг, зөөврийн рентген оношилгоо хийж, 158 хүн хамрагдаж урьдчилан сэргийлэх үзлэгт 95 хүн, эрүүл мэндийн боловсрол олгох гарын авлагыг 149 тарааж түгээв.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу Үндэсний үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин мал бүхий иргэдэд мөнгөн урамшуулал олгох журмын дагуу арьс ширээ бэлтгэж үндэсний үйлдвэрт 2017 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн тушаасан баримтыг нэгтгэн 2018 оны 1 дүгээр сард

нийт 516 малчин, мал бүхий өрхийн 1934 ширхэг падаанд бичигдсэн 38359 ширхэг арьс шир үүнээс 15932 ширхэг хонины нэхий, 20577 ширхэг ямааны арьс, 1456 ширхэг үхрийн шир, 394 ширхэг адууны ширийг арьс, ширний холбооны төлөөлөгчдөөс хүлээн авч, арьс, ширний урамшуулал олгох программд шивж орууллаа. Мөн 2019 оны 2 дугаар сард 444 өрхийн банкны харилцах дансанд 81544620 төгрөг, 4 дүгээр сард 30 өрхийн банкны харилцах дансанд 3843120 төгрөг орсон байна. 2018 оны 4 дүгээр сард малчны тэмдэг шинээр авах 9 тэмдэгийн захиалгыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, тамга тэмдэгийг эздэд нь хүргэж ажиллав.

2019 оны 4 дүгээр сарын 24-ний байдлаар зүй бусаар хорогдсон мал 5085 толгой, хээл хаясан эх мал 13570 толгой, сувайрсан эх мал 10937 толгой, төллөсөн эх мал 11557 толгой, хорогдсон төл 1542 толгой, бойжиж байгаа төл 10015 толгой байгаа дүн мэдээтэй байна.

Орон нутагт малын халдваргүйжүүлэлт, хашаа хорооны хэвтэр бууц ариутгах, хорогдсон малын сэг зэмийг устгах 2 ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилж захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд сумын ЗДТГ-ын албан хаагчид болон Онцгой байдлын газрын албан хаагчидтай хамтран Бургасан багийн Цагаан аралд хорогдсон адуу, үхэр 98ш, богийн 24ш сэг зэмийг ачиж тээвэрлэн зохих цэгт устгал хийлээ.

Гэр бүл, Хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулж буй аймгийн шилдэг хүүхэд шалгаруулах уралдаанд урлаг, спорт, сурлага хүмүүжил, нийгмийн идэвх оролцоо чиглэлээр тэргүүлж байгаа 5 сурагчийн баримт бичгийг тодорхойлолтын хамт хүргүүлээ. Сумын Бүжинхэн цэцэрлэг “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд багш нарыг ажлын байран дээр нь хөгжүүлэх харилцан туршлага солилцох зорилгоор сургалтын 6 чиглэлээр багш тус бүр мэдээлэл бэлтгэж сургалт зохион байгууллаа. Дэлхийн зөн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, БСУГ-тай хамтран 26 багш ажилчдыг хамруулан “Эерэг аргаар хүмүүжүүлье” сургалт зохион байгуулж чадавхжууллаа. Авъяас хөтөлбөрийн хүрээнд бүжиг, найрал дуу, даам, шатар, шоо үндэсний тоглоом наадгай төрлүүдээр дугуйлан хичээллүүлж, давхардсан тоогоор 140 хүүхэд хамрагдаад байна.

“Эх дэлхийн өдөр”-өөр сумын төвийн ундны усны хэрэгцээг хангадаг 10 гаруй уст цэгээс усны хими болон нянгийн шинжилгээ авч аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төв лабораторт хүргүүлээд байна.

**Үенч сум:** Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээг хүргэх “Нээлттэй хаалга”-ны өдөр арга хэмжээг зохион байгуулж, сумын нийт төрийн албан хаагчдад “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүй”, “Төрийн албаны тухай хууль”-ийн талаар сургалт хийж холбогдох байгууллагууд үндсэн чиг үүргийнхээ дагуу төрийн үйлчилгээг нэг дороос хүргэн санал хүсэлт хүлээн авч ажиллалаа.

“Хүрээлэн байгаа, орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил”- өөс урьдчилан сэргийлэх, эрүүгийн болон зөрчлийн тухай хууль сурталчлах ажлын хүрээнд прокурорын болон

оролцогч байгууллага, сумдын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх өдөрлөгт аймгийн прокурорын газар, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Булган сум дахь сум дундын прокурорын газар, Булган сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл сумын Засаг даргын Тамгын газар хамтран Алтай, Булган, Мөст, Цэцэг, Үенч сумдын төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагч, ард иргэд, мал бүхий иргэдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиудыг сурталчлан сургалт зохион байгуулж 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл хийж тодорхой төрлийн эрүүгийн хэргийн гаралт, түүний шийдвэрлэлт, шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах талаар иргэдэд мэдээлэх, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тууштай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах, цагдаагийн байгууллагад мэдээлэл өгөх, төлбөртэй авах талаар мэдээлэл хийлээ.

Монгол улсын засгийн газар, Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Солонгос улсын Эрүүл мэндийн санхүүжилт, аймгийн Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газар, Улсын их хурлын гишүүн С.Бямбацогтын хамтын дэмжлэгтэйгээр сумын эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг өргөжүүлэх төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Алслагдсан сум, багийн малчид, зорилтот бүлгийн ард иргэдэд хүргэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Мобайл технологийг нэвтрүүлэх төслийн хүрээнд зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, зөөврийн ЭХО аппарат, цусны даралт хэмжих аппарат, сахар, холестрол хэмжигч, 4 төрлийн хурдавчилсан оношлуур, шинжилгээ авахад хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгсэл, iPad зэрэг мобайл тоног төхөөрөмж хүлээн авлаа.

Сумын Ерөнхий боловсролын сургууль долоо хоногийн Мягмар гарагийг өв соёлын өдөр болгон тунхаглаж 4 дүгээр ангийн 3 бүлгийн 60 хүүхдэд ОНС танхимын үзмэр үзүүлж өв соёлоо сурталчлав.

**Цэцэг сум:** Сумын Тэргүүлэгчдийн хуралдаанаар нөхөн сонгуулийн тов тогтоох тухай, Алдаржавын 160 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж тогтоол гаргав.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас холбогдох байгууллагуудтай хамтран “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, “Хариуцлагатай, тунгалаг төр” хөтөлбөрийн хүрээнд иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээ зохион байгууллаа. Энэ үеэр аймгийн удирдлагууд цаг үеийн мэдээлэл хийж холбогдох байгууллагууд үндсэн чиг үүргийнхээ дагуу зарим төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлж ажиллалаа. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн чиглэлээр 70, эрүүл мэндийн чиглэлээр 70, тэтгэмж тэтгэвэр тогтоолтын талаар 52, иргэний бүртгэлийн чиглэлээр зөрчил арилгуулах талаар 43 иргэний санал гомдлыг хүлээн авч, нийт 200 гаруй иргэдэд мэдээлэл өгч, гарын авлага тараав.

Сумын Эрүүл мэндийн төв Зам тээврийн шалтгаант осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, иргэд олон нийтийн оролцоог хангах, аюулгүй орчин нөхцөл бүрдүүлэх осол гэмтлийн үед үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээний дэмжлэгт хяналтыг сайжруулах зорилгоор “Осол гэмтлээс сэргийлэх тогтвортой хөгжил–2030 салбар дундын үндэсний чуулган арга хэмжээг угтаж “Авто ослоор алдсаар байх уу” өдөрлөг зохион байгууллаа.

Хүүхдийн шүдний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангаж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхдийн шүдний өвчлөлийн тархалтыг 30 хувиар, цоорлын эрчмийг 4 нэгжээр бууруулах зорилгоор “Эрүүл шүд эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

**Мөст сум:** Татварын багц хууль, бусад хуулийн хэрэгжилтийн хүрээнд 75 татвар төлөгчдөд сурталчилгаа мэдээлэл хийж ажиллав. Тайлант сард 16 аж ахуйн нэгж байгууллагын хувийн хэрэгт баяжилт хийсэн.

Улсын төвлөрсөн төсөвт 861,9 мянган төгрөг оруулахаас 250,7 мянган төгрөг оруулж төлөвлөгөө 29 хувиар, аймгийн төвлөрсөн төсөвт 12,8 сая төгрөг оруулахаас 11,9 сая төгрөг буюу төлөвлөгөөг 92,6 хувиар, орон нутгийн төсөвт 2,9 сая төгрөг оруулахаас 15,9 сая төгрөг буюу төлөвлөгөөг 54,2 хувиар, нийт 16,6 сая төгрөг оруулахаас 28,1 сая төгрөг буюу 168 хувиар тус тус биелүүллээ.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 2 даатгуулагч хамрагдсан ба нийт 38 даатгуулагчийн 1281,5 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 23 даатгуулагчийн 705.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 7 байгууллагын 14244.9 мянган төгрөг, нийт 16291.6 мянган төгрөгийн орлого төвлөрсөн дүн мэдээтэй байна.

Тэтгэвэрийн сангаас 3 төрлийн тэтгэвэрт 2 арилжааны банкаар 134260.7 мянган төгрөг, 2 төрлийн тэтгэмжид 1.0 сая төгрөг, нийт 135260.6 мянган төгрөг олгосон ба тайлант сард тэтгэврийн сунгалт хөдөлгөөнийг 5 тэтгэвэр авагч хийлгэсэн ба шинээр 2 даатгуулагч тэтгэвэр тогтоолгов.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас орон даяар зохион байгуулж буй “Эрүүл аюулгүй орчин-Таны оролцоо”, “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” сарын аян өрнүүлж, аяны хүрээнд ажлын төлөвлөгөө гаргаж сумын Засаг даргаар батлуулан аяны хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Сумын төвийн айл өрхүүдийг 6 тавьтат хувааж нийт 210 гаруй ард иргэдтэй уулзаж сум орон нутагт тулгамдаж буй асуудал, цаг үеийн мэдээлэл хийж цаашид орчин тойрондоо хоггүй цэвэр орчин бүрдүүлэх, аюулгүй орчинд амьдрах талаар хэлэлцүүлэг хийж ард иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажиллалаа.

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 5 иргэнийг цалинжуулан сум тойрсон эзэнгүй хог хаягдлыг цэвэрлүүлэх, голын ай сав газар, нийтийн эзэмшлийн талбайд цэвэрлэгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

Өвөлжилт хүндхэн малын хорогдол ихээр гарсантай холбогдуулан сумын мал эмнэлгийн тасаг, Засаг даргын тамгын газар хамтран үхсэн малын сэг зэм цуглуулж устгах ажлыг багуудын Засаг дарга нартай хамтран зохион байгуулж байна.

Босоо тэнхлэгийн авто замтай Мөст сумыг 20,3 км замаар холбох ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж, гүйцэтгэгч “Хотгор зам” ХХК-тай нягт хамтран ажиллаж байна.

Сумын байгаль орчны байцаагч холбогдох хүмүүсийн хамтаар зэрлэг амьтаны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авч, 2 газарт нийт 500 кг хужир, 10 уут хивгэн тэжээл, 20 боодол өвс бэлчээрт тавьж камер байршууллаа.

Долоо хоног бүрийн 4 дэх өдөр бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж хэвшин тайлант сард 4 трактор буюу 6 тн хог хаягдлыг хогын цэгт хүргэж устгав.

Аймгийн Мал эмнэлэгийн газраас захиалагат 7 төрлийн вакциныг татан авч, шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хийж дуусгалаа.

Сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант сард улс, бүс, аймгийн хэмжээний уралдаан тэмцээн олимпиад, яргуй наадамд амжилттай оролцож ажилласны дээр анги дэвших болон төгсөх, мөн ЭЕШ-ыг бэлтгэлд орж, сонгон, давтлага тогтмол хичээллэж байна.

Хүүхдийн цэцэрлэгийн бүлгийн болон туслах багш нар сар бүр нээлттэй хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж сайжруулалт дүгнэлт хийж хүүхдийн сурах хөгжих таатай орчныг бүрдүүлэн “Авьяас”, “Номын гэгээ”, “Чадварлаг багш” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн нийт 8 төрлийн дугуйлан секц хичээллүүлж байна.

Сумын Эрүүл мэндийн төв тайлант сард урьдчилан сэргийлэх үзлэгээр 265 иргэнийг үзэж оношлон 53 хүнийг хэвтүүлэн эмчилж, 6 эхийг жирэмсэний хяналтанд авч нийт 472 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж ажиллав.

**Манхан сум:** “Цэвэр орчин” бүтээлч хөдөлмөрийн 60 хоногийн аяны төлөвлөгөө боловсруулж батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган байгууллага бүрийн нэрэмжит 7 хоног аян өрнүүлэн энэ хүрээнд сумын орчны хог хаягдал цэвэрлэх ажлыг зохион байгуулан аж ахуйн нэгж байгууллага, үйлчилгээний цэг салбаруудаар 1 өдөр цэвэрлэгээ хийлгэж, тавьтуудын цэвэрлэх газрын график гарган ЗДТГ-ын албан хаагчдаас 1, эрүүл мэндийн төвөөс 1, тавьтын ахлагч нартай хамтран тус бүр 3 хүнийг 6 тавьтад хуваарилан ирцийг бүрдүүлэх, зохион байгуулах ажлыг хариуцуулан ажиллаж 6 машин хог хаягдал, 11 машин сэг зэм хог хаягдлыг хогын цэгт хүргүүлэн устгалаа.

Сумын Засаг даргын санаачлагаар Төрийн албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулж “Төрийн албаны тухай хууль”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, уламжлал, цаашид анхаарах зарим асуудал”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж”-ийн талаар сургалт зохион байгуулж, зөвлөгөөнөөс зөвлөмж гарган хэрэгжүүлж эхлээд байна.

Суманд үйл ажиллагаа явуулж буй Хүнсний дэлгүүр, зоогийн газар, ААН-ийн эздүүдэд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн гишүүд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын тайлан цаашид анхаарах асуудал”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаар тусгайлан сургалт хийж, хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

Сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны улсын мэргэжлийн хичээлийн олимпиадын II даваанд амжилттай оролцож дараах амжилтыг үзүүллээ. Үүнд: Газарзүйн багш Ш.Отгонбаяр I байр, улсад оролцох эрхийн бичиг, газарзүйн хичээлээр 9а ангийн сурагч Г.Тэмүүлэн I байр, 12а ангийн сурагч Б.Мөнхдалай I байр эзэлж улсад оролцох эрхээр шагнагдлаа. Мөн Математикийн хичээлээр 12а ангийн сурагч Т.Амарболд II байр, мөнгөн медаль, 7б ангийн сурагч Т.Хэрлэн I байр алтан медаль, Физикийн хичээлээр 11б ангийн сурагч З.Анударь II байр мөнгөн медаль, Түүхийн хичээлээр 11б ангийн сурагч Э.Эрдэнэбилэг I байр алтан медаль, ХоИС-ийн болон нэрэмжит олимпиадуудаас тус сургуулийн сурагчид 16 медаль хүртлээ.

Сумын Хүүхдийн цэцэрлэг хүүхэд хөгжүүлэх сарын ажлын хүрээнд аймгийн “Босоо заяатай Монгол бөх” уламжлалт тэмцээн мөн Дугараа агсны нэрэмжит бий биелгээний наадамд баг, хамтлаг, гоцлол төрлөөр амжилттай оролцлоо.

Сумын Эрүүл мэндийн төв 415 үйлчлүүлэгчдэд амбулторын үзлэг шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх үзлэгт 191 хүн хамруулсан ба эмнэлэгт 44 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 40 хүүхдийг хамрууллаа.

**Ховд сум:** Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 7 удаа хуралдаж 17 асуудал хэлэлцэн тогтоол гаргав.

Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлого чиглэл, аймаг орон нутгийн цаг үеийн ажлын талаар иргэдэд мэдээлэл өгч, төрийн үйлчилгээ үзүүлэхээс гадна 2019 онд сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, хэрэгжилтийн явцтай танилцаж, ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг 4 дүгээр сарын 11-ний өдөр Ховд суманд ажиллалаа. Энэ үеэр сумын удирдлагууд болог иргэд хөдөлмөрчдийн зүгээс тулгамдаж буй хэд хэдэн асуудалд анхаарч ажиллахыг хүслээ. Тухайлбал, 160 хүүхдийн багтаамжтай дотуур байранд 225 хүүхэд амьдарч суралцаж байгаа тул өргөтгөл барьж өгөх, Улаанбураа багийн хүүхдүүдийг СӨБ-д тэгш хамруулах боломжийг нь бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, мэдээллийн хүртээмжийг сайжруулах зэрэг болно.

Тайлант сард иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар өмчлөх, эзэмших, эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхээр 26 өргөдөл хүсэлт хүлээн авч 23 өргөдлийг сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэж, газар дээр нь очиж GPS-ээр координатжуулан аймгийн тусгай зөвшөөрөлтэй “Босоо тэнхлэг” нөхөрлөлд кадастрийн зураг хийлгэж гэрээ байгуулан эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгэж

гэрчилгээжүүлэв. 1 иргэний хүсэлт Улсын тусгай хамгаалалтанд байгаа газарт багтаж байгаа учир шийдвэрлэх боломжгүй хариу өгсөн. 2 өргөдөл, хүсэлт шийдвэрлэх шатандаа хүлээгдэж байна.

Мөн газар эзэмших эрхийн гэрчилгээг арилжааны банканд барьцаалахаар 51 хүсэлт хүлээн авч тус бүр тодорхойлолт, кадастрийн зураг гаргаж, газрын цахим бирж программд бүртгэж шийдвэрлэв. Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалсаны Улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн 100161300962 тоот дансанд 510000 төгрөгийн орлого төвлөрүүлэв.

Сум орон нутгийн газрын татвар, төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор “Газрын төлбөр, татварын орлогыг биелүүлье” сэдэвт 3 сарын аян өрнүүлж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, удирдамж боловсруулан ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 152 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 6 дугаар хуралдаанаар сумын газрын төлбөрийн хувь, хэмжээг өөрчлөн батлуулж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумын хэмжээнд газар эзэмших, ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын татвар, төлбөрийн ноогдуулалтыг нэгж талбар бүрээр гаргаж биелэлтэнд хяналт тавин ажиллаж тайлант сард 1385927 төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлээ.

Сумын Засаг даргын захирамжаар Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, хүүхдийн дотуур байр цэцэрлэгийн гал тогоонд хүнсний аюулгүй байдлын хяналт шалгалт хийх ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулагдаж дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Сургууль, цэцэрлэгийн гал тогоонд ажиллагсадын эрүүл мэндийн шинжилгээ хийлгэсэн эсэх, хоол хүнсэнд хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, ашиглах хугацаа, мах, хүнсний ногооны ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ, хүнсний бүтээгдэхүүний ариутгал, хадгалалт стандартын дагуу хадгалагдаж буйд шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгч ажиллалаа.

Сумын Эрүүл мэндийн төвд үзлэг оношлогоонд 325 хүн хамрагдаж үүнэс 25 өвчтөнг хэвтүүлэн эмчиллээ. Товлолын дархлаажуулалтанд 49 хүүхэд хамрууллаа.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдөөс элсэлтийн ерөнхий шалгалт, V, IX, XII ангиудын улсын шалгалт өмнөх түвшин тогтоох шалгалт авч сайжруулах чиглэл гарган ажиллаж байна.

“Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд багш бүр өөрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, тухайн хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, сургалтын хөтөлбөрөө, шинэчлэн боловсрууллаа.

“Авъяас” хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд аэробик, гимнастик, бүжгийн дугуйлан, бишгүүр хөгжим, гитар, домборын дугуйлан, есөн хорол, шатар, даам, теннис, оньсон тоглоомын дугуйлангууд хичээллэж байна.

“Номын гэгээ” хөтөлбөрийн хүрээнд анги, бүлгүүд сургуулийн номын сангаас сонирхсон номоо уншиж, анги хамт олондоо ярьж өгөх, мэдлэгээ сайжруулахад анхааран ажиллаж байна. Мөн уншсан номынхоо хүрээнд анги хооронд үлгэрийн

баатар бүтээж, дүрийн тоглолт хийхээр сургуулийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

Үдийн цайнд нийт 20 төрлийн хүнсний зүйл, 8 төрлийн ундны зүйлийг “Хатан түнгэл” ХХК-аас авч, мах махан бүтээгдэхүүнийг сумын ард иргэдээс нийлүүлж байна. Үүнд: 1-5 дугаар ангийн нийт 224 сурагч хамрагдаж, хүнсний бүтээгдэхүүнийг долоо хоногт 1 удаа, дотуур байрны хүнсний бүтээгдэхүүнийг 14 хоногт 1 удаа ахлах тогооч цэс гарган сургуулийн эмч хянан ажиллаж байна.

**Жаргалант сум:** Сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Музей, ерөнхий боловсролын сургууль хамтран “Төрөлх хотынхоо түүхэн хөшөө дурсгалаар аялцгаая” танин мэдэхүйн сургалтыг 04 дүгээр сарын 17-23-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 600 орчим хүүхэд хамрагдсан бөгөөд Ховд хотын танилцуулга, “Ногоон хөгжилд-Бидний оролцоо”, Ховд хотын сүлд, далбаа, хүндэт тэмдэг зэрэг сэдвүүдээр яриа таниулга хийж ажиллалаа.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.2 дахь заалт, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Геннисийн номонд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, өв соёлоо сурталчлах, ахмад бие биелээчдээс үндэсний язгуур бие биелгээний үндсэн намба төрхийг суралцах, өвлөх, залуу хойч үедээ түгээн дэлгэрүүлэх зорилгоор нэрт биеч, бүжиг дэглээч, бүжигчин мугж Б.Дугараагийн нэрэмжит “Алтан өв” бие билгээний III наадмыг 2019 оны 04 дүгээр сарын 27-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Наадамд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүд, өв тээгч нийт 400 гаруй ардын авъяастнууд оролцлоо. Мөн 04 дүгээр сарын 29-ны өдөр Геннисийн номонд бүртгүүлэх нэгдсэн бичлэгийг Ард Аюушийн талбайд зохион байгуулж 1300 гаруй өв тээгч хамрагдлаа.

Сумын газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн хэлэлцүүлгийг 2019 оны 03 дугаар сарын 28-ний өдөр зохион байгуулж 70 гаруй тариаланчийг хамруулж гарын авлагаар хангалаа.

Мал эмнэлэгийн тасгийн мэргэжилтнүүдтэй хамтран хотын төвд мал аж ахуй эрхэлж буй иргэдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтын үр дүнд хотын төвөөр эзэнгүй мал бэлчээхгүй байхаар хэлэлцэн тохиролцов. Хэлэлцүүлэгт хотын төвд мал аж ахуй эрхэлж буй 40 гаруй малчин болон мал бүхий иргэн хамрагдаж санал бодлоо хуваалцлаа.

“Ховд хотын хаврын бүтээлч хөдөлмөрийн аян-2019” ажлын төлөвлөгөөг боловсруулан сумын засаг даргаар батлуулан ажиллаж байна. Ажлын хүрээнд нийтийн их цэвэрлээг албан байгууллага аж ахуйн нэгжүүдээр 2 удаа зохион байгуулсан, 12 багийн Засаг даргад албан шаардлага өгч багийн нутаг дэвсгэрийн харъяа дахь эзэнгүй хур хог, малын сэг зэмийг устгах ажлыг сумын малын эмнэлгийн албатай хамтран хийж гүйцэтгэлээ. Нийт 20 машин хог, 100 гаруй бог, бод малын сэг зэмийг устгав.



Ус ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахйн нэгжүүдийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Жаргалант сумын дэвсгэрт авто угаалгын газар ажиллуулж байгаа аж аухйн нэгжүүдэд улсын байцаагчийн хугацаатай зөвлөмж өгч ажиллаж байна.

**Эрдэнэбүрэн сум:** Сумын ИТХ-ын ээлжит 12 дугаар хуралдаан 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хуралдаж дараах асуудал хэлэлцлээ. Үүнд: Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай, Газрын төлбөрийн хураамжийг шинэчлэн батлах тухай, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай, Сумын соёлын төвийг өргөтгөх тухай саналыг хэлэлцэж батлав.

Долоо хоногийн Пүрэв гарагийг сумын хэмжээнд бүтээн байгуулалтын өдөр болгон зарлаж тус ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулж ажиллах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас санаачлан холбогдох байгууллагуудтай хамтран иргэдэд төрийн үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэх “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үеэр аймгийн удирдлагууд аймаг орон нутгийн бодлого шийдвэр, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар мэдээлэл хийв. Тус арга хэмжээний үеэр 166 иргэд оролцож хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар 37, халамжийн үйлчилгээний асуудлаар 22, нийгмийн даатгалын асуудлаар 35, газар өмчлөл, эзэмшлийн асуудлаар 26, эд хөрөнгийн бүртгэлийн асуудлаар 16, хөдөө аж ахуйн чиглэлээр 20, цахим үнэмлэх дахин олгох үйлчилгээнд 5, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 156 хүн тус бүр хамрагдаж нийт давхардсан тоогоор 369 иргэн үйлчлүүлсэн байна.

Сумын газар тариаланчдын зөвөлгөөнийг 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж газар тариалангийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай санал бодол солилцож тэдэнд байцаа, улаан лоолийн үр гардуулан өглөө. Зөвөлгөөнд газар тариалан эрхэлдэг 16 хүн оролцлоо.

Сумын Намарзан багийн нутаг “Түлэнхий бэлчир” хэмээх газар ашигт малтмалын хайгуул хийхээр ирж байрласан “Андерграунд голд майнинг” ХХК-ий ажилчид хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулах байдлыг нутгийн иргэдийн шаардлагаар албадан буулгах арга хэмжээ авлаа.

Загасны үржлийн үед хууль хэрэгжүүлэн загасыг хууль бусаар агнах явдлыг хориглох зорилгоор Шижигтийн хавцалд ЗДТГ-аас сумын байгаль орчны албаны ажилтнууд, Цагдаагийн хэсгийн ажилтнуудыг оролцуулан байнгын пост гарган ажиллуулж байна.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш сурагчид мэргэжлийн хичээлийн олимпиадад нийт 11 багш 36 сурагч оролцсоноос математикийн хичээлээр 11<sup>а</sup> ангийн сурагч Б.Шүрэн-эрдэнэ 2-р байр, сэтгэх чадварын олимпиадад 10<sup>б</sup> ангийн сурагч М.Батзаяа 2-р байр, 5<sup>а</sup> ангийн сурагч Б.Отгонбаатар 2-р байр, физикийн хичээлээр 7<sup>а</sup> ангийн сурагч Б.Очирсүлд 2-р байр, 12<sup>а</sup> ангийн сурагч Ц.Нямсамбуу 3-р байр, Газар

зүйн хичээлээр 9<sup>а</sup> ангийн сурагч Ц.Мөнгөншагай 5-р байрыг тус тус эзэлсэн амжилттай оролцлоо.

Мөн “Ховд-2019 хүүхдийн спортын бага наадам”-ын жүдо бөхийн +48 кг-ын жинд 5<sup>а</sup> ангийн сурагч Т.Ургамал аваргын алтан медаль хүртлээ. Завхан аймагт зохион байгуулагдсан 2019 оны баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд жиндээ аварга болж 5-р сард Ховд аймагт зохиогдох жүдо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан болно.

Хаврын олон төрөлт ажлын хүрээнд Ноёны хүрэм, Бяцхан хүүш, Хүрэн товгор мал эмнэлэг үржлийн нэгжүүд вакцинжуулалтын ажлыг хийж байна. Давхардсан тоогоор 301 малчин өрхийн 10600 ишгэнд шөвөг ярын вакцин, 5000 малд колибактериозын тарилга, 2300 үхэрт галзуугийн вакцин хийгээд байна.

Хаврын бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллагууд, 6-11 дүгээр ангийн сурагчид 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 13<sup>00</sup> цагаас сумын төвөөс 500 м радиуст хуваарилагдсан газар, талбайд малын сэг зэм, хог, гялгар цаас хог хаягдлыг төвлөрсөн цэгт ачиж буулгалаа. Нийт 8 байгууллагын 92 ажилтан, албан хаагчид 13 сурагчид оролцлоо.

Сумын Хүүхдийн цэцэрлэг Эрүүл мэндийн төвтэй хамтран цэцэрлэгт хамрагдаж буй 85 хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан мэргэжлийн эмч нараас багш нар зөвөлгөө авч хамтран ажиллалаа.

Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд мэдээллийн шинэ технологи нэвтэрч, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, заавар, журам, тогтоол шийдвэр мэдээллийг гар утсаараа дамжуулан авах боломж бүхий аппликейшныг сумын бүх төрийн албан хаагчид, ХААН, Төрийн банкны 123 хүний гар утсанд суулгаж ажилласан ба 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 4 даатгуулагчийг энгийн өндөр насны тэтгэвэрт, 1 даатгуулагчийг малчнаар өндөр насны тэтгэвэрт гаргаж иргэдэд үйлчлэв.

**Дуут сум:** Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан нэг удаа хуралдаж, 3 асуудал хэлэлцэн шийдвэр гарган ажиллалаа.

Тайлант сар буюу 4 дүгээр сарыг “Хүүхэд хамгааллын” сар болгон зарлаж, сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан Хүүхэд хамгааллын багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлав.

Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Хөхбэлчир, Цагаанбургас, Шивэр багийн 135 гаруй айл өрхөөр орж малчдын хаваржилтын байдалтай танилцан сум орон нутгийн ажлыг танилцуулан малчдын санал бодлыг хүлээн авлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар холбогдох байгууллагуудтай хамтран “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, “Хариуцлагатай, тунгалаг төр” хөтөлбөрийн хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэх ажлын хэсэг суманд ажиллаж Төрийн албан хаагчид, иргэдтэй уулзаж төрийн үйлчилгээг үзүүлж ажилласнаар арга хэмжээнд 80 гаруй төрийн албан хаагч, 100 гаруй иргэд хамрагдав.

Халамжийн тэтгэвэр авагч 31 иргэн, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 40, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэвэрийг 9, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 21 иргэнд тус бүр олгов.

Сумын Хүүхдийн цэцэрлэг Хүүхэд бүр цэцэрлэгт, Номын гэгээ, Авьяас, Чадварлаг багш, Боловсрол үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хүрээнд 2 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж эцэг эхчүүдэд тайлагналаа.

Багш нар ажлын байранд сурч хөгжих сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсруулан 15 туршилтын ажил шинээр санаачлан хийлээ.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгууллагын дотоод үйл ажиллагаа, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшил, багш ажилтнуудын ажилтай танилцаж зөвлөн туслав.

Сумын Ерөнхий боловсролын дунд сургууль тайлант сард боловсролын бодлого сургалт, хүмүүжлийн хүрээнд багш ажилчдыг холбогдох сургалтанд хамруулж чававхжуулсан төдийгүй “Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд аймагт зохион байгуулагдсан спортын олон төрөлт тэмцээнд холбогдох багш сурагчид амжилттай оролцож шатрын төрлөөр хошой алтан медаль, даамны төрлөөр мөнгөн медаль, теннисний төрлөөр хүрэл медаль тус тус хүртсэн.

Мэргэжлийн хичээлийн олимпиадад 20 төрлөөр багш, сурагчид оролцож, багш О.Төмөрбаатар мөнгөн медаль, сурагч Г.Маргадмаа хүрэл медаль, сурагч О.Өсөх-Ирээдүй Б.Билэгтөгөлдөр нар сэтгэх чадвараар хүрэл медаль тус тус хүртсэн амжилт гаргалаа.

Сумын Эрүүл мэндийн төв 24 өвчтөнийг хэвтүүлэн эмчилж, 180 иргэнд амбулторын үзлэг хийж, 6 эхийг эсэн мэнд амаржуулж, эхний 3 сартай 6 эхийг хяналтанд авч, 26 хүүхдийг товлолын дархлаажуулалтанд хамруулж ажиллалаа.

**Дөргөн сум:** Сумын Засаг даргын Тамгын газрын эрхзүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, “Нутгийн захиргааны байгууллагын дотоод, ажил зохицуулалт” сэдэвт 20 цагийн сургалтанд, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн ХХААХҮЯ-с зохион байгуулсан “Шинжээч малзүйч” бэлтгэх 144 цагийн сургалтанд тус тус хамруулж чадавхжууллаа. Мөн суманд Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн, Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн, Биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох сургалт хэлэлцүүлэгт холбогдох ажилтнуудыг хамрууллаа.

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг сумын иргэдэд шаардлагатай хэрэгцээт төрийн үйлчилгээг газар дээр нь “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар танилцуулахааас гадна аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, нийгмийн даатгалын хэлтэс, ГХБХБ-ын газар, улсын бүртгэлийн хэлтэсийн алба хаагчид, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, ил

тод нээлттэйгээр хүргэж, иргэдийн хүссэн үйлчилгээ, санал хүсэлтэнд хариулт өгч нийт 300 гаруй иргэд үйлчлүүлсэн.

1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 04 сарын 19-нд зохион байгуулж, цэргийн насны тодорхой тооны цэргийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Сумын Засаг даргын санаачлагаар "Мерси кор Монгол" олон улсын байгууллагын Ховд аймаг дахь зохицуулагч, сургагч багш нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулж, төлөвлөгөөг "Мерси кор Монгол" олон улсын байгууллагын санхүүжилтээр боловсруулж хэрэгжүүлэхээр боллоо. Оролцогчид сумын бэлчээрийн менежментийн алсын хараа зорилгыг тодорхойлон, түүний бүтэц, бүрэлдэхүүн, бэлчээрт тулгарч буй аюул занал, гарах арга зам, бэлчээрийн даац, нөөцийг тодорхойлох арга зүйд суралцлаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны "Нэрэмжит шалгалт, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай" А/127 дугаар захирамж мөн "Ой хээрийн түймэр болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай" А/128 дугаар албан даалгавруудын хэрэгжилт, биелэлтийн явц байдалтай танилцах, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай монгол улсын хуулиудын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх хяналтын тасгийн дарга, хошууч Г.Нэргүйгээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдэд үзлэг шалгалт хийсэн төдийгүй сумын онцгой комисс болон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд команд штабын дадлага, сургуулийг зохион байгууллаа.

Тэтгэврийн даатгалын сангаас тайлант сард 377 тэтгэвэр авагчдад 120342,6 мян төгрөгийн тэтгэвэр олгосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 271, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 33, тахир дутуугийн тэтгэвэр авагч 73 иргэнд үйлчилж, өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн 3 хүний тэтгэвэрийг шинээр тогтоов. Сайн дурын даатгалд 47 даатгуулагчийн 2602,9 мян төгрөг, эрүүл мэндийн даатгалд 38 даатгуулагчийн 883,2 мян төгрөг, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 35669,1 мян төгрөгийн шимтгэлийн орлогыг тус тус төвлөрүүлж, шинээр 2 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулж ажиллав.

Тэтгэмжийн даатгалын сангаас оршуулгын тэтгэмжид 1 хүнд 1000,0 сая төг, 2 даатгуулагчдад жирэмсэн амаржсаны тэтгэмжид 2671,2 мян төг, 1 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжид 64,5 мян төгрөг тус тус олголоо.

Аймгийн мал эмнэлгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газарт 7 хоног бүрийн 4 дэхь өдөр малын зүй бус хорогдол, төл бойжилтийн мэдээг хүргүүлж байна. Малын зүй бус хорогдол өссөн дүнгээр 1908 үүнээс тэмээ 3, адуу 52, үхэр 94, хонь 810, ямаа 949, хээлтэгч нийт 674 үүнээс ингэ 1, гүү 16, үнээ 37, эм хонь 385, эм ямаа 439, төл мал нийт 2169 үүнээс ботго 2, унага 8, тугал 9, хурга 918, ишиг 1232 тус тус хорогдсон дүн мэдээтэй байна. 4 дүгээр сарын байдлаар нийт 31529 төл бойжиж байгаагаас ботго 350, унага 86, тугал 262, хурга 8104, ишиг 22727 байна.

“Хоггүй Дөргөн “ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-г Цагаан хаалга, Өргөст хошуу, Сумын хойд дэнж, гудамж, талбай зэрэг маршрутын дагуу албан байгууллага, ард иргэдтэй хамтран зохион байгуулж, цэвэрлэгээнд 150 төрийн албан хаагч, 30 гаруй ард иргэд оролцож, 3 машин хогийг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлээ.

Өвөлжөө, Хаваржааны гэрчилгээ авах 3 иргэний хүсэлт ирснээс багийн иргэдийн нийтийн хурлаар батлагдсан нэрсийн дагуу 1 иргэнд гэрчилгээ олгож хувийн хэрэг бүрдүүлэн мэдээллийн сан үүсгэв.

Сумын Эрүүл мэндийн төв амбулатороор 356 хүнийг үзэж оношлон 36 хүнийг хэвтүүлэн эмчиллээ. Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тайлант сард шинээр 6 эхийг хяналтанд авч, товлолын дархлаажуулалтанд 0-2 хүртэлх насны 37 хүүхдийг хамрууллаа.

**Дарви сум:** Төр, аймаг орон нутгаас баримталж буй хууль тогтоомжийг сурталчлах, баримталж буй бодлого шийдвэрийн хэрэгжилтыг хангах зорилгоор соёл урлаг, уулзалт, мэдээлэл сургалт сурталчилгааны нийт 15 арга хэмжээ зохион байгууллаа.

Булаг, Мөрөн, Булган, Дэлгэр багийн иргэдийн нийтийн хурал болж сумын удирдлага 2018 онд хийсэн ажлаа танилцуулж иргэдийн санал бодлыг сонсов.

Газар тариаланчдын зөвөлгөөн, зэргэлдээх аймгийн номын санчдын туршлага судлах уулзалт зөвөлгөөн тус тус зохион байгуулагдлаа.

Сумын Номын сангийн 60 жилийн ойн хүрээнд “Хүүхдийн Монгол тоглоомын булан” байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаа ба номын фондоо 500ш номоор баяжуулах зорилт дэвшүүлэн тайлант 4 сард 30ш номоор номын фондоо баяжууллаа.

**Булган сум:** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 9 дүгээр хуралдаан 2019 оны 04 сарын 12-ны өдөр хуралдаж газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, овоо тахилгыг тахиx тухай, гүнзгийрүүлсэн сургалттай сургууль болгох тухай ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус хэлэлцлээ.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу 14 төлөвлөгөөт ажил хийгдлээ. “Газар тариалан эрхлэгчдийн” зөвлөгөөнийг 4 сарын 19-ны өдөр зохион байгуулж, нийт 60 гаруй иргэд оролцоо. Иргэдийн чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах үүднээс “Дугуйтай Булганчууд” хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд байна. Мөн “Торгуудын дууны IV” бага наадмыг 2019 оны 04 сарын 20-ны өдөр зохион байгуулсан бөгөөд бага наадамд цэцэрлэгийн сургуулийн насны дунд, ахмад үеийн төлөөлөл 4 насны ангилалаар оролцож 150 гаруй иргэд бие биелэгээ, ардын дуун, хошин дуу төрлүүдэд өрсөлдөж шилдэгүүдээ шалгарууллаа.

**Мянгад сум:** Иргэний гэр бүлийн бүртгэл, улсын бүртгэлийн чиглэлээр төрөлт 9, гэрлэлт 2, овог нэр 1, үрчлэлт 1, шилжин ирсэн 6, иргэний цахим үнэмлэх шинээр 2, 25/45 насны сунгалт 7, гээгдүүлсэн 4, гадаад паспорт 15, нийт 48 иргэний өргөдөл хүсэлтийн материалыг хүлээн авч бүртгэлд хамруулан гэрчилгээжүүлээ.

Сумын Эрүүл мэндийн төв тайлант сард нийт 314 хүнд амбулаторийн үзлэг хийж, 51 иргэнийг хэвтүүлэн эмчилж, нийт 12 удаагийн алсын дуудлаганд явж иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэлээ. 0-3 сартай 6 жирэмсэн эхийг жирэмсний эрт хяналтанд авч, хөх умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 5 эхийг 100 хувь шинжилгээнд хамруулж нийт 52 хүүхдийг товчлолын дархлаажуулалтанд бүрэн хамрууллаа.

Мөн 6 хүнийг элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулж 4 хүний цусны бүлгийг тодорхойлж, 4 хүнийг бэлгийн замын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрууллаа.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжид 93 иргэнд 13020,0 төгрөг, ахмад настан асарч буй 33 иргэнд 2508,0 мянган төгрөг тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр 24 иргэнд 5040,0 төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмж 69 иргэнд 2760,0 мянган төгрөг олгов. Цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд 15 эхэд 600,0 мянган төгрөг олголоо. Хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт 22 өрхийг хамруулж 1776,0 мянган төгрөгийг Мянгад –Ану дэлгүүрт шилжүүлэн өглөө.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд 24106,3 мянган төгрөгийн орлого оруулж, үүнээс шимтгэлийн орлого 20152,3 мянган төгрөг, сайн дурын даатгалд 32 иргэнээс 2553,2 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалд 31 иргэнээс 1400,8 мянган төгрөгийг тус тус орууллаа.

Тайлант сард шинээр тэтгэвэр тогтоолгох 6 иргэнээс өргөдөл хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлж тэтгэврийн тогтоолт хийв.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 152525,1 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 351 хүнд 100997,0 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 36 хүнд 10728,5 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 68 хүнд 39799,6 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 2 хүнд 1272,5 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 2000,0 мянган төгрөгийн санхүүжилт жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 3 хүнд 4120,9 мянган төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 1 хүнд 67,5 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг тус тус олголоо.

Аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудын 2019 оны 01 дүгээр улирлын тайлан шивэлт илгээлтийг хянан стандарт түвшинг ханган ажиллаж ОДЦЭ ХХК, Тунгалаг буянт ХХК-ны удирдлагуудтай уулзаж ОДЦЭ ХХК-ны түгээмэл тархацтай ашигт малтмалын урд оны өр 2000,0 мянган төгрөгийг барагдуулан орон нутгийн орлогын дансанд орууллаа.

Аймгийн татварын хэлтсийн татвар төлөгчтэй харилцах тасагтай хамтран татвар төлөгчдөд татвар төлөгчдийн нэгдсэн системээр сургалт явуулан 27 татвар төлөгчийг хамруулан ажиллалаа.

Мал эмнэлгийн тасаг нь тайлант сард 8 төрлийн мэдээг МЭҮ-ний нэгжүүдээс гаргуулан авч нэгтгэн аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүллээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулж буй “Эрүүл аюулгүй орчин таны оролцоо”, “Иргэдийн оролцоотой байгаль орчин хяналт” сарын аяны

хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд иргэдийн оролцоог хангах, иргэдэд мэдлэг мэдээлэл олгох зорилго бүхий бусад 4 багийн төлөөллийг оролцуулсан Цагаанбулан багийн ИНХ-ын жишиг хуралдаанд оролцож, Алтанхөхий уулын БЦГ-ын өргөтгөл хийх төслийн саналыг хэлэлцүүлээ энэ үеэр Байгаль орчны багц хууль, эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн хүрээнд 295 иргэнд хууль эрх зүйн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, иргэдийг холбогдох гарын авлагаар ханган ажиллалаа.

Мөн сумын төвлөрсөн ус хангамжийн худаг, байгууллагуудын шугамын ус, Ховд голын ундны усанд хийгдсэн шинжилгээний дүн мэдээг иргэд, олон нийтэд мэдээлж ажиллав.

Иргэнээс ирүүлсэн гомдол мэдээллийн мөрөөр Чацарганат багийн Хүрэн харгана хэмээх газраас эзэн холбогдогч нь тодорхойгүй 400 ширхэг нойтон бургасыг хураан авч үнэ тогтоох сумын зөвлөлийн шийдвэрээр 1500 төгрөгөөр зах зээлд борлуулахаар төлөвлөөд байна.

Суманд баригдах 10 мегаваттын “Нарны цахилгаан станц”-ын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийсэн “Сату” ХХК-тай хамтран үнэлгээний тайланг Баянхошуу багийн ИНХ-аар хэлэлцүүлээ.

Увс аймгийн Наранбулаг сумаас Ховд аймгийн Булган сумын боомтруу төмрийн хүдэр зөөвөрлөхдөө Мянгад сумын нутагт пүү /жин/ байршуулан төмрийн хүдрийг буулган үйл ажиллагаа явуулж буй “Гайхам” алтайн нуруу ХХК-ны ажилд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгахаар албан шаардлага хүргүүлээд байна.

**Мөнххайрхан сум:** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 удаа, сумын Засаг даргын зөвлөл 1 удаа, Тамгын газрын хурал 1 удаа, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 3 удаа тус тус хуралдаж сумын цаг үеийн тулгамдсан асуудал, бүтээлч ажил, айл өрх, албан байгууллагуудын гадна тохижилт, төсөв, хөрөнгө зарцуулах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргаж ажиллав.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг 4 дүгээр сарын 15-ны өдөр суманд ажиллаж, “Нээлттэй хаалганы өдөр” зохон байгуулж, иргэд, төрийн албан хаагчидтай уулзалт хийж, иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэв. Энэ арга хэмжээнд нийт 165 хүн оролцож, 41 хүн үйлчлүүлж, зөвлөгөө мэдээлэл авлаа.

Сумын баг, албан байгууллагуудын дунд “Нэг байгууллага-Нэг өрх” 1 сарын аяныг 4 сарын 01-ээс 5 сарын 01 хүртэл өрнүүл, айл өрхүүдийн дунд “Хашаандаа сайхан амьдарья” болзолт уралдаан зарлаад байна.

Сумын ХАА, МЭ-ийн тасгаас “Мал эмнэлгийн ариун цэврийн сарын аян”-ны удирдамж боловсруулан энэ хүрээнд зудаар хорогдсон малын сэг зэм устгах ажлыг зохион байгуулж 4 багийн нутаг дэвсгэрт 5 чиглэлд 200 гаруй бод, 1500 бог малын сэг зэмийг устгалаа. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Үндсэний бичиг соёлын аян” өрнүүлж, аяны хүрээнд “Монгол бичгийн олимпиад”,

“Сайхан бичигтэн” тэмцээн, “Хурдан уншлага”-ын уралдаан зохион байгуулж шилдгүүдээ шалгарууллаа.

Жил бүр улалмжлал болон зохион байгуулдаг мэргэжлийн хичээлийн олимпиадад 55 багш, сурагчид амжилттай оролцож, мэдлэг чадвараараа өрсөлдлөө. Хүүхдийн спортын бага наадамд 60 сурагч, 2 багш бэлтгэл ханган оролцож, 20 гаруй медаль хүртлээ.

Аймгийн цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулсан “Байгаль нийгмийн орчин” олимпиадад цэцэрлэгийн багш Б.Амартэмүүлэн оролцож, багш ажилтнууд хамтран “Таван хошуу” мал сэдвээр сургалтын хэрэглэгдэхүүн хийж үзэсгэлэн гаргалаа.

Цэцэрлэгийн эцэг, эхийн хурал зохион байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл, “Сургалтын хэрэглэгдэхүүн”, “Давсны хэрэглээг бууруулцгаая” сэдэвт сургалт, Олон нийтийн оролцоот сургууль, “Цэцэрлэг-Хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөрийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулж, нийт 42 эцэг эх оролцсон.

Нийлэг хальсан уут, улавчны хэрэглээг багасгах зорилгоор олон нийтийн оролцоотойгоор “Даавуун тор, улавч оёцгооё” аян өрнүүлж, бүлэг бүр 50-60ш тор, 30-40ш улавч оёж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Сумын Эрүүл мэндийн төв эмийн бус эмчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхдэд үйлчилсэн. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 0-2 насны 23 хүүхдэд товлолын дагуу дархлаажуулалтанд 100 хувь хамруулж, дархлаажуулалтын товлолд Пневмококк, Халдварт саагийн идэвхгүйжүүлсэн вакцин нэвтэрч уг вакцинаар 2 сартай 5, 5 сартай 6 хүүхдийг товлолын дагуу дархлаажууллаа.

Сумын Соёлын төв нь 5 удаагийн урлагийн арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 521 иргэнд үйлчилсэн. Номын сангаар 5 уншигч шинээр карт нээлгэж, 15 иргэдэд 46 ном хэвлэлээр үйлчлэв.

Орон нутгийн хамгаалалттай газрын сүлжээг өргөтгөх ажлын хүрээнд Алаг, Хаг багийн нутаг дамнасан 27305,41 га газрыг ой, ус, ургамал, ан амьтны онцгой бүс нутаг болох “Дунд Цэнхэр” нэртэй газрыг орон нутгийн хамгаалалтанд авч ажиллав.